

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДУГААР

ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 38 (2302)

1974 оны 5 дугаар сарын 16 ПҮРЭВ

ҮНЭЭ ГҮҮНИЙ НИЙЛҮҮЛЭГ

Үхэр сүргийг өсгөхөд шийдвэрлэгч нөхцөл нь хээлтэгч бүрт бүрэн хээл авахуулах явдал мөн.

Бод мал ид төлөж хөдөө орон нутагт бод малын хээлтүүлгийн компани ажил эхлэх хугацаа боллоо.

Энэ жил аймгийн хэмжээгээр 118,5 мянган бод хээл авахаас зөвхөн 3,1 мянган бод хээл аваад байна.

Аймгийн намны хорооны VI бүгд хурлаас мал өсгөх 1974 оны төлөвлөгөөг 5 төрөл дээр нь биелүүлж таван жилийн хөдөлмөрийг төлөвлөгөөг дүнгээр нь биелүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд бод малын хээлтүүлгийн талаар өнгөрсөн онд гаргасан аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны 6/58 дугаар тогтоолын заалт бүрийг ширхэгчлэн биелүүлж, 2 жилийн хугацаагаар зарласан уралдааны болзолыг ханган биелүүлэхэд үхэрчин, адуучид, нийт саальчид, мал аж ахуйн мэргэжилтэн нарын хүчийг чиглүүлэн ажиллах нь орон нутгийн нам, улс, хөдөө аж ахуйн байгууллагуудын чухал зорилт болж байна.

Бод малын хээл авалт олонх сумдад 85 хувиас доошгүй байгаа нь өнгөрсөн оны хээлтүүлгийн компани ажлыг сайн зохион байгуулж бод малын хээл хамгаалах ажил муугүй хийгдсэний үр дүн мөн.

Энэ ололтондоо тулгуурлан өнөө жилийн бод малын хээлтүүлгийг явуулахдаа үнээг зохиомол ба гардан аргаар гүүг хэсэгчлэн азарга, азаргаар цөөлөн хээлтүүлэх журмаар 5 дугаар сарын 20-ны дотор хээлтүүлгийн ажлын бэлтгэл зохион байгуулалтыг хангаж нийт үхэр, адуунд хаврын зоо-мал эмнэлгийн үзлэг, заазлалт явуулж үржилд тэнцэхгүй үнээ гүүг ялган тусгаарлаж заазлагдсан бүх азаргыг акталж хөнгөлөх, шинээр нөхөн тавих тохироог тэгшитгэх нь зүйтэй.

Хээлтүүлгийг зохион явуулах график төлөвлөгөөг гаргаж, эхний ээлжинд сувай орсон, эрт төлөсөн, хээл хаясан үнээ, гүүг хээлтүүлэхээр зохион байгуулж, бүх бүхыг нэмэгдэл тэжээлд оруулж үрийн чанар, бэлгийн идэвхийг шалган үзсэн байх шаардлагатай. Шинээр хээлтүүлэгт орох байдсан гүүг өөр азаргад ялган хураалгаж гуягийн үнээг нас гүйцсэн үнээний биеийн жингийн 70—75 хувьд хүрсэн үед нь хээлтүүлэх журмыг тогтоох нь зүйтэй.

Үнээний ороог илрүүлэхэд хээлтүүлгийн хуанлийг ашиглаж гаднын шинж тэмдгээр нь илрүүлэхийн хамт туршигч бүхыг ашиглах нь найдвартай.

Үнээ гүү нэг бүрийг хээл авахуулахад хээлтүүлгийн болон төлөөлтийн бүртгэл журналыг суурь, саальчин нэг бүрт нарийн хөтөлж байх нь ашигтай.

Хээлтэгч бүрийг бүрэн хээл авахуулахад үржлийн тарга хүчтэй байлгаж, анхны ороонд нь хээл авахуулахын тулд гардан ба зохиомол хээлтүүлгийн салбарын пунктуудыг шаардлагын дагуу 1—2 суурийн дунд байгуулж бүхыг тусгай маллан хоногт 7-гоос доошгүй тэжээлийн нэгжээр тэжээж өдөрт 2 удаа ашиглах нь хээлтүүлсэн үнээний хээл авалтад илүү нөлөөтэй.

Хээлтүүлгийн үед сүргийн дотор эзэнгүй бүх явуулахыг хатуу цээрлэж, саальчин, суурь бүрт бүхыг зүслүүлэн хариуцуулж шөнийн цагт удаан амраах, нэмэгдэл тэжээл өгөх, өглөө оройн сэрүүнд хээлтүүлэгт ашиглаж байх, гүүг хэт олноор нь фермэн сааж азаргагүй барьдаг явдлыг зогсоож цөөн ээлжээр унагыг унж гүүг заавал азаргатай нь байлгахар гүү бүрийг бүрэн хээл авахуулж байгаа тэргүүний адуучдын туршлагыг эзэмших ажил зохиох нь зүйтэй. Бод малын хээлтүүлгийн явдал тавих хяналт шалгалтыг хүчтэй болгож хянах шалгах аппаратын бүхий л хүчийг энэ зүгт чиглүүлэн, ололт туршлагуудыг хэвлэл радиогоор сурталчилж нийтийн хүртээл болгохын зэрэгцээгээр оршиж байгаа дутагдлыг илрүүлэн тухайн үед шаардлагатай арга хэмжээ авч байх нь орон нутгийн нам, улс, ХАА-н байгууллага, мал аж ахуйн мэргэжилтэн нарын эрхэм зорилт байх ёстой.

Үхэр, адууг байнгын хариулгатай болгож үхэрчин, адуучин, саальчдын дунд социалист уралдааныг өрнүүлж 7 хоног тутам тогтмол дүгнэж байвал зохино.

КОММУНИСТ СУББОТНИКООР

Заамар сумын төвийн үйлдвэр аж ахуйн газрын албан хаагчид, ажилчид 4 дүгээр сарын 22, 5 дугаар сарын 5-ны өдрийн бүх нийтийн субботникоор 3222 төгрөгний ажил хийж хүрмтлэлийн фондол оруулав.

Энэ субботникоор 120 кв.м метр барилгын мод гуалин бэлтгэж малын 17 хашаанд засвар үйлчилгээ цэвэрлэгээ хийж тохижуулав.

Нийтийг хамарсан энэ субботникт 8 жилийн дунд сургууль, нэгдлийн уурын зуухны хамт олон бусдаасаа идэвхтэй оролцдоо гэж манай сурвалжлагч идэвхтэн А. Цогдон цахилгаанаар мэдээлэв.

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХҮРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ

Согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай

Согтуурах явдал нь иргэдийн нийгмийн өмнө хүлээх хариуцлага, идэвхийг сулруулж, гэр бүл саринулах, өсвөр үеийн хүмүү жилд муугаар нөлөөлөх, хүний эрүүл мэндэд хор хүргэх, танхайрах, гэмт хэрэг үйлдэх, осол аюул гарах, хөдөлмөрийн сахилга бат зөрчиж, улс ардын аж ахуйд хохирол учруулахын нэг гол шалтгаан болж байна.

Согтуурах явдалтай хийх тэмцлийг улам хүчтэй болгох талаар хөдөлмөрдөөс тавьсан зүй ёсны хүсэлт, шаардлагыг харгалзан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдээс

ТОГТООХ НЬ:

1. Согтуурах явдалтай хийх тэмцлийг улам хүчтэй болгож, хүнийг хүмүүжүүлэх хамт олны нөлөөг дээшлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг байгууллагынхаа хэмжээнд байнга авч байхыг улс, хоршоолол, олон нийтийн байгууллагын эрх баригчдад даалгасгай.

2. Ресторан, аймгийн төв, орон нутгийн хотын төв гуанзнаас бусад нийтийн хоолны газар, үйлдвэр, албан газар, байгууллага, оюутан, сурагчдын нийтийн байр, сууцны орн, доорхи давхар дэлгүүр, сургууль, эмнэлэг, гу-

дамж, талбай, цэнэрлэг, цэнгэлдэх хүрээлэн, зах зээлийн газар, галт тэрэгний болон авто зам, нисэх онгоцны буудал, үзвэр, олон нийтийн үйлчилгээний газар согтууруулах ундааны зүйл уухыг хориглосгай.

Энэ зүйлд заасныг зөрчсөн буюу согтууран хэвийн бус байдал гаргасан этгээдийг 25—200 төгрөг хүртэл торгоно.

3. Шаардлагатай гэж үзвэл согтууран хэвийн бус байдал гаргаж байгаа этгээдийг 24 цагаас дээшгүй хугацаагаар тусгай байранд байлган эрүүл (Төгсгөл нь II нүүрт)

САНСРЫН НИСГЭГЧ В. ГОРБАТКО НАЙРАМДЛЫН НИЙГЭМЛЭГИЙН ДАРГА БОЛОВ

Энэ оны 4 дүгээр сарын 22-нд Зөвлөлт—Монголын найрамдлын нийгэмлэгийн төв захиргааны хуралдаан болов.

Манай хоёр орны ард түмний уламжлалт найрамдалт харилцааг бэхжүүлэх талаар тус нийгэмлэгээс зохиож ирсэн олон талт ажлыг Зөвлөлт Холбоот Улсад ч Бүгд Найрамдах Монгол Ард

Улсад ч сайн мэдэх билээ. Энэ нийгэмлэгийн үйл ажиллагааг иргэний дайны баатар, Зөвлөлт Холбоот Улсын гурван удаагийн баатар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар, Зөвлөлт Холбоот Улсын маршал Семен Михайлович Будённый олон жилийн турш даргалж иржээ. Энэ хураалдаан дээр ЗСБНХУ-ын

сансрын нисгэгч, Зөвлөлт Холбоот Улсын баатар, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар В.В. Горбатког тус нийгэмлэгийн төв захиргааны даргаар санал нэгтгэж сонгов.

В. В. Горбатко ондөр итгэл найдвар хүлээлгэсэнд талархлаа илэрхийлээд, Зөвлөлт—Монголын ард түмний найрамдлыг бэхжүүлэх ариун үйлсэд хүч чадлаа хайрлахгүй зүтгэнэ гэдгээ илэрхийлэв. Зөвлөлт—Монголын найрамдлын нийгэмлэг 1973 онд хийсэн ажлынхаа дүнг гаргав.

Өнгөрсөн онд тус нийгэмлэг Монгол ардын хувьсгалын 52 жилийн ой, Зөвлөлт—Монголын хооронд найрамдал, хамтран ажиллах, харилцан туслах тухай гэрээ байгуулсны хорин долоон жилийн ой, Д. Сүхбаатарын мэндэлсний 80 жилийн ой, Зөвлөлт—Монголын найрамдлын нийгэмлэг байгуулагдсаны 15 жилийн ой, БНМАУ-ыг тунхагласны 49 жилийн ойд зориулсан арга хэмжээг Зөвлөлт улсад зохиоход гол анхаараа хандуулжээ.

Монгол—Зөвлөлтийн найрамдлын уламжлалт сарын үеэр тус нийгэмлэг "Хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд Зөвлөлт улсын тэргүүн туршлагыг авч хэрэглэх өдөр зохиоход идэвхтэй оролцсон билээ."

Төл бойжилтын явц

Аймгийн хэмжээгээр 5 дугаар сарын 13-ны байдлаар төлөвлөх зохих эх малын 78,2 хувь буюу 495,4 мянган мал төлөж гарсан төлийн 98,5 хувь буюу 492,1 мянга нь буюу өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 23,3 хувь буюу 92,9 мянган толгойгоор илүү бойжиж байна.

Төл бойжилтыг сумдаар байр эзлүүлбэл:

Сумдын нэрс	Бойжилтын хувь	Эзлэх байр
Баянцагаан	100,0	1
Баян	99,8	2
Угтаал	99,7	3
Баянжаргалан	99,5	4
Баянцогт	99,5	5
Эрдэнэсант	99,4	6
Дэлгэрхаан	99,4	7
Сэргэлэн	99,4	8
Алтанбулаг	99,2	9
Дүн	99,2	10
Өндөрширээт	99,2	11
Баянчандмань	99,1	12
Баянзүрх	99,1	13
Мөнгөнморьт	99,1	14
Баян-өнжүүл	99,1	15
Борнуур	98,9	16
Батсүмбэр	97,8	17
Бүрэн	96,8	18
Эрдэнэ	96,8	19
Жаргалант	95,8	20
Баяндэлгэр	95,1	21
Заамар	94,2	22

Статистикийн товчоо

В. ЭФРОС

БНМАУ-ЫН АРДЫН ИХ ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ЗАРЛИГ

Төгсгөл. (Түрүүч нь 1 нүүрт)

жүүлж, зардалд түүнээс 25 төгрөг гаргуулан авна.

4. Согтууран хэвийн бус байдал гаргаж яваа хүнийг автобус, үзвэр, олон нийтийн үйлчилгээний газар оруулсан буюу үйлчилсэн, согтууруулах ундаагаар шахаж, бусдыг согтоосон этгээдийг 100 төгрөг хүртэл торгоно.

5. Согтууран агсагнасан этгээдийг шаардлагатай гэж үзвэл эрүүл мэндэд нь хор хохиролгүйгээр эрүүлжүүлэх арга хэмжээ авч болохыг иргэдэд зөвшөөрсөнгүй.

6. Нэг жилийн дотор удаа дараа согтуурчээрчил гарган захиргааны болон олон нийтийн арга хэмжээ авагдсан этгээдэд үйлдвэрчний эвлэлийн хороотой харилцан зөвшөөрөлдсөний үндсэн дээр хөнгөлөлтэйгөөр олгох амралтын эрхийн бичиг болон урамшил шагнал олгохоос хасах, орон сууц олгох дарааллыг хойшлуулах эрхийг үйлдвэр, албан газар, байгууллагын эрх баригчдад олгосугай.

7. Насанд хүрээгүй хүнд согтууруулах ундааны зүйл уулгасан этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал 25-100 төгрөг хүртэл торгоно.

8. Насанд хүрээгүй хүмүүс согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглосугай. Энэ журмыг зөрчсөн, ажил хөдөлмөр эрхэлдэг 16—18 насны хүмүүсийг 50 төгрөг хүртэл торгох, бусад насанд хүрээгүй хүмүүсийн эцэг, эх, асран хамгаалагчийг 50 төгрөг хүртэл торгох буюу олон нийтийн арга хэмжээ авахуула.

9. Согтууруулах ундааны зүйл үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдах ажилд насанд хүрээгүй хүн авч ажиллуулсан албан тушаалтныг 50 төгрөг хүртэл торгоно.

10. Согтууруулах ундааны зүйл бэлтгэх, худалдах талаар доорхи

үйлдлийг хориглосугай.

а) дэлгүүр, мухлаг, агент, ресторан, аймгийн төв, орон нутгийн хотын төв гуанзанаас бусад газарт архи, дарс худалдах;

б) архи, дарс, пивыг дэлгүүр, мухлагт 19 цагаас лараа өдрийн 10 цаг хүртэл худалдах;

в) ресторан болон аймгийн төв, орон нутгийн хотын төв гуанзанд архи, нэг хүнд 100 граммаас илүү худалдах ба гаднаас согтууруулах ундааны зүйл авчирч уух;

г) насанд хүрээгүй хүнд архи, дарс, пиво худалдах;

д) согтуу хүнд архи, дарс, пиво худалдах;

е) амралт, баяр ёслолын урьдах өдөр 16 цагаас хойш болон амралт, баяр ёслолын өдөр архи, дарс худалдах;

ж) иргэд сүүнээс өөр зүйлээр согтууруулах ундааны зүйл бэлтгэх;

з) үдэшлэг, зугаалга дээр согтууруулах ундааны зүйл худалдах;

11. Согтууруулах ундааны зүйл бэлтгэх, худалдах журмыг зөрчигчдэд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ.

а) согтууруулах ундааны зүйл худалдах журмыг зөрчсөн худалдааны байгууллагын ажилтныг 50—200 төгрөг хүртэл торгоно.

б) сүүнээс өөр зүйлээр согтууруулах ундааны зүйл бэлтгэх буюу тэдгээрийг бэлтгэх хэрэгсэл бий болгосон этгээдийг 25-200 төгрөг хүртэл торгож, бэлтгэсэн зүйлийг хураан авна.

в) согтууруулах ундааны зүйлийг хувийн журмаар бэлтгэж худалдсан этгээдийг 100—500 төгрөг хүртэл, мөн худалдан авсан этгээдийг 50 төгрөг хүртэл торгоно.

г) согтууруулах ундааны зүйлийг ашиг хонжоо олгох зорилгоор худалдан авсан буюу дамлан худалдсан этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал 100-500 төгрөг хүртэл торгож, сог-

тууруулах ундааны зүйл болон орлогыг хураан авна.

12. Согтууруулах ундааны зүйл уусан үедээ авто техник жолоодохыг хориглосон заалтыг зөрчигчдэд дор дурдсан хариуцлага хүлээлгэнэ.

а) согтууруулах ундааны зүйл уусан үедээ авто техник (авто машин, мотоцикл, цахилгаан тээврийн болон бусад машин, механизм) жолоодож явсан жолоочийг 50—300 төгрөг хүртэл торгож, авто техник жолоодох эрхийг 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хасна.

б) авто техник жолоодох эрхээ урьд хасуулсан жолооч уг хугацаа дууссанаас хойш гурван жилийн дотор согтууруулах ундааны зүйл уусан үедээ авто техник жолоодох эрхийг хойроос таван жил хүртэл хугацаагаар хасна.

в) авто техник жолоодох эрхгүй этгээд согтууруулах ундааны зүйл уусан үедээ авто техник жолоодвол 200—500 төгрөг хүртэл торгоно.

г) авто техник жолоодож яваа хүнд согтууруулах ундааны зүйл уулгасан буюу хамтарч уусан этгээдийг 25—200 төгрөг хүртэл торгоно.

13. Авто техник жолоодож явахдаа согтууруулах ундааны зүйл уусны улмаас буюу бусад шалтгаанаар осол аюул гаргаж, ял шийтгүүлсэн жолоочоор ялаа эдэлж байгаа хугацаанд нь техник жолоодуулсан буруутай этгээдийг 50—200 төгрөг хүртэл торгоно.

14. Энэ зарлигийн 12, 13 дугаар зүйлд заасан арга хэмжээг Улсын цагдан сэргийлэх газрын авто техникийн хэргийг шалган байцаах байгууллага, бусад торгууль болон арга хэмжээг цагдан сэргийлэх байгууллага, сум, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаа авч, арга

хэмжээ авагдсан этгээдийн тухай түүний ажиллаж, сурч, оршин суугаа газрын захиргаа буюу олон нийтийн байгууллагад заавал мэдэгдэнэ.

15. Согтууруулах ундааны зүйл хэтрүүлэн хэрэглэснээс гэр бүлээ эд материалын гачигдалд учруулсан этгээдийг жижиг хэлцэл хийхээс бусад цалин хөлс, тэтгэвэр болон бусад орлогыг авах ба зарцуулах талаар эрх олгох, үүрэг буй болгох чадварыг шүүх хязгаарлаж, дээр дурдсан орлогыг авах ба зарцуулах эрхтэй хүнийг түүний гэр бүлийн гишүүдээс томилж байсугай.

16. Сайн дураар эмчлүүлэхээс зайлсхийсэн буюу эмчлүүлсний дараа дахин согтууруулах ундааны зүйл байнга хэрэглэж байгаа, түүнчилэн захиргааны буюу олон нийтийн арга хэмжээ авсаар байтал согтууруулах ундааны зүйл үргэлжлүүлэн хэрэглэж хөдөлмөрийн сахилга бат, нийгмийн хэв журам зөрчсөөр байгаа архаг архичин этгээдийг түүний ажиллаж байгаа газрын хамт олон, олон нийтийн байгууллага, орон сууц байгаа газрын захиргааны байгууллага, гэр бүлийн хүмүүийн хүнсэлтээр 1—2 жил хүртэл хугацаагаар тусгай эмчилгээний газарт шүүхийн магадлалаар албадан эмчилж байсугай.

Шүүхийн магадлалд заасан хугацаанаас өмнө эмнэлгээс гаргах асуудлыг эмч нарын комиссын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ.

Харин дахин албадан эмчлүүлж буй этгээдийг хугацаанаас өмнө эмнэлгээс гаргаж болохгүй.

17. Албадан эмчлүүлэх тухай шүүхийн магадлалд биедүүлээгүй эмнэлгийн байгууллагын буруутай ажилтныг цагдан сэргийлэх байгууллага 100-300 төгрөг хүртэл торгоно.

18. Согтуурсны улмаас хөдөлмөрийн чадвараа түр

алдагсад хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын хөрөнгөнөөс тэтгэмж олгохгүй.

19. БНМАУ-ын эрүүгийн хуульд доорхи агуулгатай «171-ийн 1» дүгээр зүйлийг нэмсүгэй.

«171-ийн 1» дүгээр зүйл. Насанд хүрээгүй хүнийг согтууруулах явдалд уруу татах

Насанд хүрээгүй хүнийг уруу татан удаа дараа согтууруулах ундааны зүйл уулгасан этгээдийг 1 жил хүртэл хугацаагаар хорих буюу 1 жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл 500 төгрөг хүртэл торгож шийтгэнэ.

20. Энэ зарлиг гарсантай холбогдуулж, «Уж согтуурах явдалтай тэмцэх тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1960 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 198 дугаар зарлиг; «Уж согтууран авто машин, өөрөө явагч бусад машин механизм жолоодогдод хүлээлгэх хариуцлагыг чангатгах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1967 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 13 дугаар зарлигийн 1-5 дугаар зүйл; «БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1960 оны 198 дугаар зарлигт өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1970 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 128 дугаар зарлигийн тус тус хүчингүй болсон тооцсугай.

21. Энэ зарлигийн 1974 оны 4 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нэгдүгээр орлогч дарга

С.ЛҮВСАН

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Ц.ГОТОВ

1974 оны дөрөвдүгээр сарын 8. Улаанбаатар

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ФОНД

Манай нам, засгаас өсвөр үеийнхний сайн сайхны төлөө байнга анхаарал халамж тавьж байдгийн нэг илрэл нь өнгөрөгч онд МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс хүүхдийн төлөө фонд байгуулах шийдвэр гаргасан явдал мөн.

Манай орны нийт хөдөлмөрчид хүүхдийн төлөө фонд бий болсныг халуунаар дэмжин хөрөнгө хуримтуулах хөдөлгөөн нийт олныг хамарч 1973 онд улсын хэмжээгээр 5 сая шахам төгрөг хүүхдийн төлөө фондод оруулжээ.

Манай аймгийн үйлдвэр, аж ахуйн газар, нийт сум

өнгөрөгч оны 5 дугаар сарын 27-ны Ням гаригт бүх нийтийн өргөн суботник хийж хүүхдийн төлөө фондод 163,9 мянган төгрөг оруулсан юм.

Хүүхдийн төлөө фондын хөрөнгөөр 1973 онд тус бүр 25 ортой таван цэцэрлэг барьсны нэгийг Дэлгэрхаан суманд барьж байгуулан цэцэрлэгийн хүүхэд багачуудын бие бялдар, сэтгэл санаанд тохирсон аятай тохитой эдлэл хэрэглэл, орчин үеийн тоглоомоор өвч төхөөрөмжилсөн юм.

«Хүүхдийн төлөө фондод хөрөнгө хуримтлуулах талаар гарсан санаачлагыг дэмжих тухай»

МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 20 дугаар тогтоолд заахдаа: 1973—75 онд нам, улс, олон нийт, хоршооллын байгууллагад ажиллаж байгаа ажилчин, малчин, албан хаагчид, их дээд, тусгай мэргэжлийн дунд сургуулийн оюутан, сурагчдын дотор сайн дурын үндсэн дээр тэдний нэг өдрийн цалин хөлс буюу нийтийн өргөн суботникоор хүн бүрийн нэг өдрийн цалин хөлстэй тэнцэх хэмжээний ажил хийж олсон хөрөнгийг хүүхдийн төлөө фондод хувь нэмэр болгон хуримтлуулах ажил зохион байгуулах хэрэгтэй гэжээ.

Иймд бүх сум, нэгдэл,

САА, нэгдэл дундын үйлдвэр, ТАА, үйлдвэр аж ахуйн газар, албан байгууллагууд 5 дугаар сарын 19-ний өдрийн суботникийг сайн бэлтгэлтэй хийж байгууллагынхаа дүнгээр нэг өдрийн цалингийн фондтой тэнцэх хэмжээний мөнгийг хүүхдийн төлөө фондод оруулах хэрэгтэй.

Энэ онд аймгийн хэмжээгээр хүүхдийн төлөө фондод 220,5 мянган төгрөг оруулах хяналтын төлөвлөгөөг 6 дугаар сарын 1-ний дотор биелүүлж манай жаргалант ирээдүй хүүхэд багачуудын сурч хүмүүжихэд нь гүн их туслахаа үзүүлэх нь чухал байна.

П.ЖАНЧИВ



Аймгийн Зам ашиглалтын ангийн жолооч, намын гишүүн Т.Сэмжаан У таван жилийн төлөвлөгөөг 2 жил 2 сарын өмнө 100,8 хувиар биелүүлжээ.

С.БОЛД зураг

Малын зүй бусын ХОРОГДОЛТОЙ ТЭМЦЬЕ

Угтаалын САА-н дарга БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат Д. Батчулуун малай сурвалжлагчийн асуултад хариулсныг дор нийтэллээ.

АСУУЛТ: Танай сум өнгөрсөн жил мал өсгөх улсын төлөвлөгөөг давуулж гялалзсан амжилт олсон.

Өнөө жилийн бүх ард түмний социалист уралдаанд мал өсгөх талаар ямар амлалт авсан бэ?

ХАРИУЛТ: Мал өсгөх улсын төлөвлөгөөг 111,1 хувиар биелүүлж зүй бусын хорогдлыг урьд жилийн дундажаас 37,5 хувиар багасгах үүрэг авсан, одоогийн байдлаар төл бойжилт 99,9 хувьтай байна. Малын тоо толгой V таван жилийн төлөвлөгөө-

ний эцэст байх хэмжээнд хүрсэн явдалд манай малчид их урамтай, жил нь ч муугүй байна. Энэ амлалтаа бид биелүүлэхийн тулд бүх малчдыг уралдаантай ажиллуулж ойр ойрхон дүгнэж байна. Мал өсгөхөд малчин бүрийн хариуцлага их чухал.

АСУУЛТ: Малын зүй бус хорогдлыг багасган мал сүргийн тоог тогтвортой өсгөх талаар МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс гаргасан тогтоолыг хүлээж аваад зохион байгуулалтын ямар

арга хэмжээ авсан бэ?

Үүний үр дүн юу болж байна?

ХАРИУЛТ: Малын зүй бусын хорогдлыг багасгах сумын штаб тодорхой төлөвлөгөө гаргаж юуны урьд сүүлийн дөрвөн жилд мал хорогдсон гол шалтгаанд судалгаа хийж үзлээ. Судалгааны дүгнэлтээс үзвэл манай сумын мал хорогдлын 05 хувь нь арчилгааны муугаар, 03 хувь нь халдварт өвчнөөр 3,4 хувь нь халдваргүй өвчнөөр, төл малын хорогдол 5,1 хувийг эзэлж байна. Иймээс бид өвчтэй малыг тэжээл эмчилгээний цэгт бүрэн төвлөрүүлж мал эмнэлгийн байгууллагын ажиллагааг улам сайжруулж тэжээл, эмчилгээний цэгийг жинхэнэ ажиллагаатай малын «болон» болгох талаар их анхаарлаа.

Энэ жил нийт эмгэгтэй

малаа хоёрцэгт эмнэсний үрээр малын хорогдол нолонгийн энэ үеэс 55,1 хувиар бага байна.

Түүнчлэн тэжээлийн дундаж цэг байгуулж эдгэрсэн малыг бордон тариулаж ядалгаа хийсэн нь ихээхэн үр дүн өгөв.

Цаашид дундаж цэгийн үр ашгийг улам дээшлүүлнэ.

АСУУЛТ: Малын хээл хаялт, сувайралт хир зэрэг байна?

ХАРИУЛТ: Энэ жил 200 хонь сувайрч, 320-иод хонь хээл хаясны дээр үнээ гүүний сувайралт бас байна. Сувай үнээг тусгайд нь ялгаж бүх тавих арга хэмжээ авлаа.

АСУУЛТ: Төл голчлон ямар шалтгаанаар хорогдож байна вэ?

ХАРИУЛТ: Төл хорогдож байгаа шалтгаанд мөн л судалгаа хийж үзлээ. Мал ид төлөөд ир-

хийн үед эх хурга хоёрыг таньж цагт нь хөхүүлэхгүй, хашаа хорооны дулаалга муугаас хүйтний цочролд оруулах зэргээр малчны ажиллагаатай холбогдож хатгалга, биж өвчнөөр хорогдож байна.

Хаваршаад ирэхийн үед эхий нь дагуулж явуулснаас төл турж сэнсрэн яргуй хөөсөн малын явдал гүйцэхээ байдаг.

Ийм байдалд орохгүйн тулд малчин нэг бүрийн чармайлт дээр тэжээлийн нөөц хэрэгтэй байгаа юм. Иймээс саяхан сумын нам, захиргааны байгууллагаас нийт төлчид малчдад захидал бичлээ.

Тэргүүний малчдынхаа туршлагыг шинжлэх ухааны ололтой хослуулан нийт малчдад эзэмшүүлж чадвал зүй бусаар мал хорогдохын үүд хаагдана шүү дээ.

Аймгийн ХАА-н нэгдлийн бригадуудыг 1974 оны нэгдүгээр улирлын зарим ажлаар нь социалист уралдаанд цуваагаар байр эзлүүлсэн дүн

1974—5—8

Сумын нэр	Бригадын нэр	Эзлэх байр
Баян	Цавчир	1
Баяндэлгэр	Төвийн	2
Заамар	Ухаа	3
Алтанбулаг	Ферм	4
Баян	Цант	5
Баянзүрх	Тэрэлж	6
Баян	Баян	7
Эрдэнэ	Эрдэнэ-уул	8
Эрдэнэсант	Сайхан	9
Эрдэнэсант	Угалзат	10
Алтанбулаг	Жаргалант	11
Эрдэнэ	Хушинга	12
Мөнхморьт	Байдлаг	13
Баянзүрх	Туул	14
Мөнгөнморьт	Хэрлэн	15
Мөнгөнморьт	Бүрэх	16
Эрдэнэсант	Баян-уул	17
Эрдэнэ	Нарстай	18
Баян-өнжүүл	Бараат	19
Баяндэлгэр	Байдлаг	20
Алтанбулаг	Алтанбулаг	21
Баянцагаан	Алтай	22
Бүрэн	Баянцогт	23
Дэлгэрхаан	Давст	24
Баян-Өнжүүл	Бүрд	25
Баян-Өнжүүл	Цээл	26
Заамар	Тосон	27
Сэргэлэн	Хишиг	28
Эрдэнэсант	Алтан-уул	29
Баянцагаан	Гурван түрүү	30
Лүн	Энх	31
Бүрэн	Булангаа	32
Баянцагаан	Баян-айраг	33
Өндөрширээт	Баясах	34
Баянжаргалан	Баян-эрхтий	35
Алтанбулаг	Алтан-овоо	36
Заамар	Ундарган	37
Баянжаргалан	Жаргалант	38
Баяндэлгэр	Гүн галуут	39
Баянзүрх	Баянбүрд	40
Бүрэн	Хайрхан	41
Лүн	Цагаан-уул	42
Өндөрширээт	Баян-туул	43
Өндөрширээт	Уянга	44
Дэлгэрхаан	Тарган	45
Сэргэлэн	Авдар	46
Баянцагаан	Өлзийт	47
Өндөрширээт	Наранбэлэг	48
Лүн	Өгөөмөр	49

АЙМГИЙН ХААУ ГАЗАР

НЭГДЛИЙН ЗӨВЛӨЛ



Борнуурын САА-н тракторч Дашдэлэг, Балжинням, Баяртогтох, Очирбат нар төмсний үр суулах өдөр бүрийн нормоо давуулан биелүүлж 6 өдрийн ажлыг 5 өдөрт амжуулж байна. Л. ГУНГААБУУ-гийн авсан зэрэл зураг

Аймгийн пионерын залгамжлагч V чуулган

Саяхан аймгийн пионерын залгамжлагч V чуулган Зуунмод хотод болоо. Залгамжлагч V чуулганы ажиллагааг аймгийн ХЗЭ-ийн хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга П. Жанчив нээсний дараа «Монголын Пионерын байгууллагын 50 жилийн ой угтаж зохиосон «Залгамж үе» аяны нэг жилийн ажлын дүн» гэсэн илтгэлийг Пионерын зөвлөлийн дарга Д. Хандсүрэн тавилаа. МПБ-ын 50 жилийн ой угтсан залгамж үе аяны удирдамжийг аймгийн Пионерын зөвлөл хүлээн авч тэргүүлэгчдийн хурлаараа хэлэлцэн тодорхой төлөвлөгөө гаргаж нийт сургуулийн пионер сурагчдаар үүрэг амлалт авахуулсны дээр 11 сургуулийн пионерын байгууллагын ажлыг шалган зааварчилж, 3 сургууль дээр хамтарсан үзлэг явуулжээ. Түүнчлэн Ардын боловсролын хэлтэстэй хамтран аймгийн тэргүүний бүлэг салаа шалгаруулах болзол гарган дүгнээд 19 салаа шалгарч, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний зөвлөлтэй хамтран хүүхдийн тоглоомын тал-

бай шалгаруулж 25 газар шинээр хүүхдийн тоглоомын талбайтай болжээ.

Мөн нийт пионерын бүлгэмийн ажлыг оноогоор байр эзлүүлэн дүгнэж тэргүүний бүлэгт шилжин явах туг шилжүүлж байгаа зэрэг зохион байгуулалтын тодорхой удирдлагаар хангаж ажилласны үрээр аяны хугацаанд сурлагын хувь өнгөрсөн оноос 2,3 хувиар ахиж 1000-аад сурагч дундаас сайн, 500-гаад сурагч сайнаас онц сурлагатан болжээ. Мөн Д. Нацагдорж тэмдэгтэн 71, таван онцын эзэн 26, номын сайн нөхөр тэмдэгтэн 93 болж биеийн тамир спорт болон олимпиадын аварга шалгаруулах тэмцээнд тус аймгийн пионер сурагчид амжилттай оролцсон байна.

Залгамж үе аяны үлдэж буй хугацаанд тэргүүний бүлэг салаа болох хөдөлгөөнийг улам эрчимжүүлж пионерын ажлыг үйлдвэр аж ахуй, соёл шинжлэх ухааны газруудаар өргөн зохиож эрдэмтэн мэргэжилтэн, ахмад зүтгэлтнүүдтэй уулзуулах, сурлагын чанарыг улам бүр сайжруулан сурагчдын

тал бүрийн авьяас билгийг хөгжүүлэхэд пионерын байгууллага зохиох ажлынхаа голыг чиглүүлэхэд залгамжлагч V чуулганы зорилт чиглэгдэв.

Залгамжлагч чуулганд тавигдсан илтгэлтэй холбогдуулж Баяндэлгэр сумын пионерын ахлах удирдагч Цэдэнбал, Эрдэнэсант сумын 8 жилийн дунд сургуулийн онц сурлагатан Оюунбилэг, Батсүмбэрийн онц сурлагатан Уламбаяр нарын зэрэг 10 гаруй пионер, багш үг хэлсний дээр аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга Х. Билгээ дэлгэрэнгүй үг хэллээ.

Мөн чуулган дээр Жаргалантын 10 жилийн дунд сургуулийн сурагч Цогзолмааг МПБ-ын атлан медаль, 8 жилийн дунд сургуулийн сурагч Энхжээ мөнгөн медаль, Төвийн 10 жилийн дунд сургуулийн сурагч Оюунчимэг, Эрдэнэ сумын 8 жилийн дунд сургуулийн сурагч Батцэцэг нарыг хүрэл медаль мөн Эрдэнэ сумын онц сурлагатан Ц. Баасанжавт ЗХУ-д жуулчлах эрхийн бичиг гардууллаа. Ш. ЦЭРЭНДОО



АШИГТАЙ АЛХАМУУД

■ Португалийн байдал

■ Франц дахь сонгуулийн явц

● Португалд 4 дүгээр сарын 25-ны өдөр төрийн эргэлт гарснаар фашист дарангуйлагч О.Салазарын хойчийг залгамжлагч Марсельд Каэтанугийн засгийн газар унав. Энэ эргэлтийн гол хүч нь арми байв. Эргэлтийн дүнд генерал Антонио Ди Спинолагаар толгойлуулсан үндэсний аврах зөвлөл засгийн эрхийг гартаа авлаа.

Үндэсний аврах зөвлөлийн программ нилээд дэвшилттэй юм. Программын гол санаа нь Португалд ардчилсан эрх чөлөөг сэргээн тогтоож, бүх нийтийн шууд, нууц сонгууль явуулж үндэсний хурлыг сонгох, колонийн дайныг цэрэг зэвсгийн хүчээр биш улс төрийн

аргаар нэг тийш болгон шийдвэрлэхэд чиглэжээ.

Португал улс Европ тивийн баруун өмнө хэсэгт Пиренейн хойг дээр орших бөгөөд 92 мянган ам дөрвөлжин километр газар нутагтай, 9,5 сая хүн амтай юм. Харин Португал өөрийн газар нутгаас бараг 23 дахин их нутаг дэвсгэр бүхий 14 сая хүн амтай олон орныг колоничлон тэдгээрийн ард түмний үндэсний эрх чөлөөг нугачин дарж байлаа. Португал оронд олон түмэн ямарч эрх мэдлэг хамгийн ядуу амьдралтай учир Португалын 1 сая иргэн гадаадад цагаачлан гарсан байлаа. Энэ бүхнээс болоод Португалын фашист дэглэмийн дотоод гадаад боллого гүнзгий хямралд орж, ард түмний эсэргүү-

цэл тэмцэл цэгтээ хүрсэн юм.

Фашизмыг эсэргүүцсэн Португалын ажилчин анги, нийт ардчилсан хүчний тэмцлийг 1921 онд байгуулагдаад 1926 онд нууц байдалд орсон Португалын коммунист нам удирдан зохион байгуулж байна.

М.Каэтанугийн фашист дэглэмийг түлхэн унагаасан үндэсний аврах зөвлөл амласан ёсоороо улс төрийн хоригдлуудыг суллаж, хэвлэлд тавьсан хориг цагдлыг цуцлан, фашист дэглэмийн захирамжаар тавигдсан албан хаагчдыг сольж байна.

Португалын шинэ засгийн газар фашист нууц цагдаагийн газрыг тарааж улмаар улс төрийн намуудын үйл ажиллагааг сэргээн ил ажилладаг бол-

гох, түүнчилэн Португалын «Далайн чанд дахь колони эзэмшлийн» асуудлыг улс төрийн аргаар зохицуулахын тулд зохих арга хэмжээ авах, Португалын колони нутаг орны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний төлөөлөгчидтэй хэлэлцээ хийхэд бэлхэн байгаагаа илэрхийлээд байна.

Гадаад бодлогын хувьд шинэ засгийн газар бусад улсын хэрэгт хөндлөнгөөс үл оролцох, энхтайвныг хамгаалах, найрамдал, хамтын ажиллагаанд тулгуурлан олон улсын харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх зарчмыг удирдлага болгохоор албан ёсоор зарлав.

Шинэ засгийн газрын эдгээр анхны арга хэмжээ нь Португалын хүн амын өргөн дэмжлэг талархалыг хүлээж байгаа юм.

● Францын ерөнхийлөгчийн сонгуулийн анхны шат энэ 5 дугаар сарын 5-ны өдөр явагдлаа.

Сонгуулийн урьдчилсан

дүнгээс үзвэл: засгийн газрын олонхийн нам болох Бүгд Найрамдах улсын төлөө ардчилсан үзэлтнүүдийн холбоо намын дэмжлэгийг хүлээсэн ерөнхий сайд агсан Ж.Жабан Делмас бүх сонгогчийн 18 хувийн санал авч хасагджээ.

Биеэ даасан Бүгд Найрамдахчуудын үндэсний холбооны удирдагч, эдийн засаг, санхүүгийн яамны сайд Д.Эстан бүх сонгогчдын 32,9 хувийн санал авсан ба зүүний хүчний нэр дэмжлэг хүлээн тэдний нэр дэвшүүлсэн Францын Социалист Намын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ф.Миттеран бүх сонгогчдын 43,3 хувийн санал авч II шатны сонгуульд Эстэнэйт үлдсэн юм.

Энэ сарын 19-ний өдөр болох Францын II шатны сонгуульд Д.Эстан, Ф.Миттеран хоёрын аль олон хүний санал авсан нь Францын ерөнхийлөгчөөр сонгогдох болно.

Д.ДУЛАМЖАВ

ХАВАР

Өвлийн шуурган дунд эрдэнийн дээд санагдах Өнгө нэхий дээл мөр дарах ч янзтай Өргүүлж орсон шиг хэгд өвс голж Өвөлжөөгөө орхин яргүй хөөх ч шинжтэй Оройн хонь хотлохдоо хашаанаасаа цэрвэж Олон жилийн бууцат хотын хөл рүү дурлаад Бараадан байж өвөлжсөн уулын минь өвөлжөө Баавгайн арьсан дах шиг халуу оргих боллоо. Уулсын сайхан хангай давчуу дээл шиг санагдаж Унаган тал бодогдон хавар ингээд ирэхэд Тана эрдэнийн налай өргөө гэрээ ачаалаад Таван эрдэнийн далай их сүргээ туугаад Талын шаргал нарны үдлэх тэртээ алсад Тамирын цагаан хун шиг маргаашийн нарнаар очих билээ.

Хангайн модыг харуулдан байж хашаагаа барьсан юм.

Хадахын ихээр хадан байж өвсөө татсан юм. Халуун амь шингээ хайрлан байж малаа дагасан юм. Хатан дэлхийд завгүй явж өвлийг давсан юм. Цангийн цагаан өвлөөсөө уйдаана үгүй байтал Цагийн сайхан хавар удалгүй ингээд ирлээ. Цайдам талын зунтайгаа учран золгоё гэвэл Царам хангайн өвлийг арга үгүй туулна.

Д.ЦООДОЛ

ЧОНЫН ХОР ХӨНӨӨЛ

Чоно мал, ан амьтадыг идэж сүйтгэхээс гадна хүн малд халдварт, шимэгч хорхойн өвчнийг тараан дамжуулж, өөрөө уг өвчний голомт болж байдаг. Чоно нь хоногт олон арван километр газар хэсүүчлэн тэнэж хоол эрж явагдсаараа галзуу, боом, шүлхий зэрэг өвчнийг хурдан хугацаанд тараадаг нь нотлогджээ.

Чонын амьдрал нь байгалийн хатуу ширүүн аль ч нөхцөлд төсвөртэй зохицдог бөгөөд удаан хугацаагаар өл даадаг эсвэл хоол олдсон үед нь үлэмж хэмжээгээр идэж бас чаддаг байна.

Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд чоно хоногт 4,4—5,9 кг мах, 3 хоног өлөн явсаны дараа 11 кг

мах иддэг нь судлагджээ. Гичийн чоно жилд нэг удаа хээл аваад 63—65 хоног хээлтэй явж 4 дүгээр сарын сүүлч 5 дугаар сарын эхээр төрж, 5—8 заримдаа 12 хүртэл бэлтрэг төрүүлдэг байна.

Иймд мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангаж малын зүй бусын хоргодлыг багасгахад чоныг хөдөө орон нутагт зохион байгуулалт, бэлтгэл сайтайгаар агнах ялангуяа цаас орсоны дараа мөр хайж бэлтрэг, гичийн чоныг устгах нь чухал юм.

Мөн түүнчилэн бэлчээрт яваа бүх малыг байнга хариулж, адуун сүргийг тогтмол манаатай болгож хэвшүүлэх хэрэгтэй байна.

Я.АМАРТҮВШИН

Хөдөлмөрчдийн хууль ЗҮЙН МЭДЛЭГТ

ЭРҮҮГИЙН ЯЛ ШИЙТГЭЛИЙН ТУХАЙ

Тогтоол. (Түрүүч нь 37 дугаарт)

Гэмт хэрэг үйлдэх үед 18 нас хүрээгүй байсан хүмүүс ба 60-аас дээш насны эрэгтэйчүүд, 50-наас дээш насны эмэгтэйчүүдэд 10 жилээс дээш хорих ял шийтгэхгүй.

Нутаг зааж суулгах гэдэг нь ял шийтгэгдсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаатайгаар зайлуулах тодорхой нутаг зааан суулгахыг хэлнэ. Энэ ялыг 2-оос доошгүй, 5-аас дээш жилээр шийтгэхгүй. Нутаг заан суулгагдсан этгээдийг хөдөлмөрт зохион байгуулахыг орон нутгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаад хариуцна.

Уг нутгаас зайлуулах ял гэдэг нь шийтгэгдсэн этгээдийг оршин суугаа нутгаас нь хугацаа зааж албадан зайлуулахыг хэлнэ. Ялыг 2—5 жилийн хугацаагаар оногдуулна.

Засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял нь шийтгэгдсэн этгээдийг хорихгүйгээр эрүүгийн хуульд заасан хугацаагаар хөдөлмөрт албадан ажиллуулж түүний цалин хөлснөөс зохих хувийг суутган авахыг хэлнэ. Ялыг 1 сараас доошгүй, 1 жил 6 сараас дээшгүй хугацаагаар оногдуулах бацалингийн 10—25 хувийг суутгана. Энэ талаар шийтгэгдсэд нь ялын хугацаанд ээлжийн амралт болон бусад хөдөлмөрийн хугацаатай холбогдон гарах тэтгэвэр тэтгэмж авах эрхээ алдана. Уг эт-

гээд ялаас зайлсхийвэл хорих ялаар солино.

Ямар нэг албан тушаал гүйцэтгэх буюу ажил хэрэг эрхлэхийг хориглох ялыг үндсэн ба нэмэгдэл ялын алины ч хувьд шүүхээс хэрэглэж болдог.

Шүүх энэ ялыг хэрэглэхдээ 1—5 жилийн хугацаагаар тогтооно. Хэрэв энэ ялыг нэмэгдэл ялын хувьд хэрэглэж байгаа бол уг этгээд зохих хорих ялаа эдэлж дууссаны дараа энэ нэмэгдэл ялаа эдэлж эхлэнэ.

Харин энэ ялыг хорихоос өөр ялд нэмэгдэл ялын хувьд оногдуулсан бол үндсэн ялаа эдэлж эхэлсэн өдрөөс тоолно.

Торгох ял гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдээ эрүүгийн хуульд тодорхойлсон хэмжээгээр зохих тооны мөнгө гаргуу-

лан авч улсын орлогод авахыг хэлнэ.


Харин улсын орлогод хураан авч байгаа мөнгө бүр торгох ял бишээ.

Гагцхүү эрүүгийн хуулиар зохих зүйл ангиар гаргуулж байгаа ял үүнд хамаарагдана.

Олон нийтийн өмнө буруушаах ял гэдэг нь шүүхээс гэмт этгээдийг олон нийтийн өмнө буруушаан эмзэмлэж, шаардлагатай гэж үзвэл хэвлэлд нийтлэх буюу өөр аргаар олон нийтийн сонорт хүргэхийг хэлнэ.

Хөрөнгө хураах ял гэдэг нь шийтгэгдсэн этгээдийн амины өмч буюу бусадтай хамтарсан дундын өмч болох хөрөнгөнөөс түүнд оногдох хэсгийн бүгдийг буюу заримыг үнэ төлбөргүйгээр хурааж улсын санд нийлүүлэхийг хэлнэ. Хуульд зааснаар хөрөнгө хураах ял нь бүх хөрөнгийг, хөрөнгийн заримыг, хуульд заасан тусгай зүйлийг хураах гэсэн 3 хэлбэртэй байна.

Б.ЖУНАЙ



Крымийн улсын амралтын «Хараагийн үүр» гэдэг талбай ТАСС-ын гэрэл зураг

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ